

2018 оны завсрын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл, агуулга

Дундговь аймаг дах Төрийн аудитын газар
Санхүүгийн аудитын алба

2018 он 10 сар

Завсрын аудит хийх үндэслэл

- ▶ 1. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дугаар тушаалаар баталсан “ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАС САНХҮҮГИЙН АУДИТ ХИЙХ ЖУРАМ”-ын 9.1.2 /Завсрын буюу аудитыг төлөвлөх үе шат. /
- ▶ 2. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторын баталсан 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.6 /2018 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд хийх завсрын аудит/

Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн /2018 оны 10 сарын байдлаар:/

- ▶ Завсрын аудитаар нийт 271.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс:
 - ▶ Төлбөрийн акт 0.5 сая төгрөг;
 - ▶ Албан шаардлага 250.4 сая төгрөг;
 - ▶ Зөвлөмж 10.2 сая төгрөг;
 - ▶ Залруулсан алдаа 6.8 сая төгрөг
 - ▶ Залруулагдаагүй алдаа 3.2 сая төгрөг тус тус байна.

Нийтлэг гарч буй зөрчлүүд

- ▶ Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан хоолны норм норматив мөрдөөгүй;
- ▶ Шатахууны тооцоо бодож гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
- ▶ Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн;
- ▶ Засгийн газрын тогтоол болон сайдуудын хамтарсан тушаалаар баталсан нэмэгдлүүдийг илүү тооцох, ажлыг дүгнэлгүй хавтгайруулж олгосон;
- ▶ АИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмыг мөрдөж ажиллаагүй;

д/д	Данс	Зөрчлийн агуулга, зөрчсөн хууль, тогтоомж	ЗДТГ	ЭМТ	Цэцэрлэг	Сургууль
1	Хөрөнгө	<p>Хүнсний материалыг батлагдсан нормыг мөрдөлгүй хяналтгүй зарцуулсан /Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаал/-ыг мөрдөөгүй, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтэгдэхүүний жишиг”</p>		<p>Цагаандэлгэр, Баянжаргалан , Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай</p>	<p>Дэлгэрхангай , Өлзийт, Хулд</p>	<p>Цагаандэлгэр, Баянжаргалан , Сайхан-Овоо</p>

д/д	Данс	Зөрчлийн агуулга, зөрчсөн хууль, тогтоомж	ЗДТГ	ЭМТ	Цэцэрлэг	Сургууль
2	Зардал	<p>Шатахууны тооцоо бодсон актанд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, жолоочийн замын хуудсанд ажил үүрэг гүйцэтгэсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 <i>/Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/</i> хэсгийг зөрчсөн.</p>		Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай		

д/д	Данс	Зөрчлийн агуулга, зөрчсөн хууль, тогтоомж	ЗДТГ	ЭМТ	Цэцэрлэг	Сургууль
3	Анхан шатны бүртгэл	Эд хариуцагчийн ажлыг хүлээлцэхдээ хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулж баталгаажуулаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2 <i>/хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ...эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед .../</i>		Цагаандэлгэр, Эрдэнэдалай		
4	Анхан шатны бүртгэл	Агуулахын бүртгэл болон ажилчин, албан хаагчийн эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй, тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй . Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 <i>/Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/</i> хэсгийг зөрчсөн.	Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрхангай	Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Эрдэнэдалай	Өлзийт	Цагаандэлгэр, Гурвансайхан, Өлзийт,

д/д	Данс	Зөрчлийн агуулга, зөрчсөн хууль, тогтоомж	ЗДТГ	ЭМТ	Цэцэрлэг	Сургууль
5	Зардал	Ажлын бодит үр дүнг үнэлэлгүй үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон. МУ-ын ЗГ-ын 150-р тогтоолын 1.5 / улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзан ... олгоно/ хэсгийг зөрчсөн		Өлзийт, Хулд		
6	Зардал	Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгохдоо журманд заасан шалгуурын дагуу ажлыг үнэлээгүй. Энэ нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын 5-т <i>/Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна./</i> заасныг зөрчсөн.	Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрхангай Цагаандэлгэр, Сайхан-Овоо			

д/д	Данс	Зөрчлийн агуулга, зөрчсөн хууль, тогтоомж	ЗДТГ	ЭМТ	Цэцэрлэг	Сургууль
7	Орлого	<p>Хөрөнгийг гэрээ байгуулалгүй, үнэ төлбөргүй ашиглуулсан, буудлын барилга, цайны газрын барилгын хувийн хэрэгт барилгын хэмжээнүүдийг буруу бичсэн, буудлын орлогын тооцоог бодохдоо хяналт тавиагүй, баталгаажсан үнэт цаасаар тооцоо бодоогүй, орлого төвлөрүүлээгүй, Түрээсийн гэрээг АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмч хөрөнгө түрээслүүлэх журам" зөрчин байгуулсан. <i>Энэ нь АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмч хөрөнгө түрээслүүлэх журам"-ын холбогдох заалтуудыг зөрчсөн.</i></p>	Өлзийт, Эрдэнэдалай, Дэлгэрхангай,	Өлзийт, Хулд		Сайхан-Овоо

Давтан гарсан буюу ноцтой зөрчил

8

Зардал

Нүүрсний үнийг анхан шатны баримтгүйгээр төрийн бус байгууллагын дансанд шилжүүлсэн. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 */анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/* -г зөрчсөн. Зөрчлийг давтан гаргасан.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар энэ зөрчилд албан шаардлага өгөгдсөн байхад нүүрсний хөнгөлөлтийн зөрүүг төрийн бус байгууллагын дансанд шилжүүлж мялаалга наадам хийсэн.

▶ АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД БАЯРЛАЛАА